



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 11 сарын 11 өдөр

Дугаар А/460

Улаанбаатар хот

「Баянзүрх дүүргийн 167 дугаар цэцэрлэгийн эргэлтийн бус хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэг, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны А/82 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2024 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн 11 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 1,355,200.00 (нэг сая гурван зуун тавин таван мянга хоёр зуу) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг Баянзүрх дүүргийн 3 дугаар цэцэрлэгийн балансад шилжүүлж, данс бүртгэлээсээ хасахыг Баянзүрх дүүргийн 167 дугаар цэцэрлэг (Б.Баярмаа)-т зөвшөөрсүгэй.

2. Шилжин ирсэн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартыг баримтлан хавсралтын дагуу бүртгэж авах, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Баянзүрх дүүргийн 3 дугаар цэцэрлэг (Ч.Уртнасан)-т даалгасугай

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, ашиглалт, дотоод аудитын хэлтэс (Г.Тэмүүжин)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



В.ОЮУМАА



Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны 11 дүгээр сарын 11-ны өдрийн 2146 дугаар тушаалын хавсралт

Балансаас балансад шилжүүлэх хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Баянзүрх дүүргийн 167 дугаар цэцэрлэг

№	Эд хөрөнгийн нэр	Марк дугаар	Ашиглалтад орсон огноо	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ /2024.10.28/	Хуримтлагдсан элэгдэл /2024.10.28/	Үлдэгдэл өртөг /2024.10.28/	Шилжүүлэн авах байгууллага
1	Угаалгын машин	WH500W	2023.05.26	ш	2	677,600.00	1,355,200.00	383,973.36	971,226.64	Баянзүрх дүүргийн 3 дугаар цэцэрлэг
Тоног төхөөрөмжийн дүн								383,973.36	971,226.64	